



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛБӨР ТООЦООГ МОНГОЛБАНКААР ДАМЖУУЛАН ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

Монголын хөрөнгийн зах зээлд оролцогчдын төлбөр тооцоог олон улсын жишигт хүргэх зорилгоор Монголбанк Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТТТХТ)-ийг банк хоорондын гүйлгээний төлбөр тооцооны Санхүүгийн дундын сүлжээнд холбож, үнэт цаасны төлбөр тооцоог онлайн горимоор бодит цагт гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ.

Үүний үр дүнд хөрөнгийн зах зээлд оролцогчдын хувьцаа болон бондын арилжааны төлбөр тооцоог түргэн шуурхай, бодит цагт гүйцэтгэхээс гадна дараах давуу талууд бий болох юм.

- Төлбөр тооцооны нууцлал аюулгүй байдлыг ханган ажиллах. ҮЦТТТХТ нь төлбөрийн системийн оролцогч болсоноор төлбөрийн мэдээ болон харилцах дансны мэдээлэл нь зөвхөн тухайн оролцогч тал тайлж уншиж, илгээж чадах нууцлалын шифрлэлтийг ашиглах тул нууцлал, аюулгүй байдалтай холбоотой эрсдлийг бууруулж чадна.
- Төлбөрийн эрсдлээс сэргийлэх. ҮЦТТТХТ-ийн төлбөр тооцоонд ашиглагдах Монголбанкинд хөрөнгийг байршуулснаар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой эрсдлийг арилгаж чадна.
- Төлбөр тооцооны эрсдлийг бууруулах. Банксүлжээ систем нь төлбөрийн эцэслэлтийг баталгаажуулах тул хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоо нь DvP зарчмын дагуу хийгдэх боломж бүрдэж, төлбөр тооцоо хийгдээгүйтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг төлбөрийн эрсдлээс сэргийлж чадна.

Дашрамд дурьдахад, Монголбанкинд ҮЦТТТХТ-ийн төлбөр тооцоонд ашиглагдах данс нээгдэх ба хөрөнгийн зах зээлд оролцогчдын данс тус байгууллага ба арилжааны банкинд байрших юм.

ФОТО СУРВАЛЖЛАГА







МОНГОЛБАНК